



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 1/80

Улаанбаатар хот

**Биеийн тамир, спортын хамтлаг
шинэчлэн байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2006 оны “Хамтлаг байгуулах тухай” 165 дугаар захирамж, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх орон тооны бус биеийн тамир, спорт хамтлагийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн болон байгууллагын хэмжээний тэмцээн уралдаанд оролцох баг бүрэлдэхүүнийг удирдлагаар ханган зохион байгуулах, биеийн тамир спортын хамтлагийн ажлын тайланг нийслэлийн Нийтийн биеийн тамир спортын хороонд хүргүүлж ажиллахыг спорт хамтлаг /Д.Ариунбаатар /-т даалгасугай.


3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2018 оны А/262 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 26 өдрийн 80 дугаар тушаалын хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Спорт хамтлагийн ахлагч:	Д.Ариунбаатар	/Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч/
Гишүүд:	А.Эрдэнэмөнх	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Ч.Чулуунтөгс	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Т.Азжаргал	/Захиргаа, санхүүгийн хэлтсийн архивын ажилтан/
	Ш.Дашдорж	/Уртцагаан үйлчилгээний төвийн менежер/
	Б.Эрдэнэчулуун	/Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн/
Спорт хамтлагийн нарийн бичиг:	Э.Дөлгөөн	/Захиргаа, санхүүгийн хэлтсийн бичиг хэргийн ажилтан/